216

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/44 Сүмбэр сум

"Ирээдүйн эзэд-2021" мэргэжил сонголтын аян зохион байгуулах арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Ирээдүйн эзэд-2021" мэргэжил сонголт аяны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Ирээдүйн эзэд-2021" мэргэжил сонголтын аяныг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Урангоо)-д даалгасугай.

3.Тус үйл ажиллагаанд зарцуулагдах 198 000 / нэг зуун ерэн найман мянга / төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч Д.Оюунцэцэгт даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

217

ГБХЗХгазрын даргын 2021 оны
.06.сарын.03.-ны өдрийн.Ш/44
дугаар тушаалын 1..-р хавсралт

“ИРЭЭДҮЙН ЭЗЭД-2021” МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 оноос эхлэн “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг 21 аймаг, 9 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын анхлах ангийн сурагчдад ирээдүйд эзэмших мэргэжил сонголттой холбоотой арга зүйн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт бус байдал, ажилгүйдэл, ядуурлын эх үүсвэрийг бууруулахад нөлөөлөх зорилгоор жил бүрийн 5 сард уг аяныг зохион байгуулдаг.

2020-2021 оны хичээлийн жилд Говьсүмбэр аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах буюу 9-12-р ангийн нийт 941 сурагч суралцаж байна. Эдгээр суралцагчдад мэргэжил сонголтын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, төгсөх ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хэрэгцээ шаардлагатай үүсч байна.

Хоёр. Зорилго

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн эрэлт хэрэгцээг таниулах, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой.

Гурав. Зохион байгуулагч

Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Дөрөв. Хамтран зохион байгуулагч

Дуу бүжгийн Боржигин чуулга

Тав.Хамрах хүрээ

Ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн сурагчид.

Зургаа. Хугацаа

2021 оны 05 сарын 03-ны өдрөөс 05 сарын 25-ны өдрүүдэд.

Долоо. Зохион байгуулах арга хэмжээ, хэлбэр

- “Мэргэжил сонголт миний ирээдүй" цахим сургалтыг ахлах ангийн сурагчдад зохион байгуулах
- Мэргэжил сонголт Говьсүмбэр фэйсбүүк цахим группээр дамжуулан мэргэжил сонголттой холбоотой цахим зөвлөгөө, мэдээлэл нийтлэн түгээх

D:/Бичиг хэрэг /тушаал

- Цахим хуудсаар дамжуулан ганцаарчилсан зөвлөгөө өгөх, төгсөгчдөд зориулсан тэтгэлэг хөтөлбөр болон бусад Их, дээд сургуулиудын мэдээллийг түгээх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Мэргэжил бүхэн сайхан” цуврал контент хийж олон нийтэд түгээх.

Ес. Хүлээгдэх үр дүн

- Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.4.6 дахь зорилтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх
- Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл, ирээдүйн чиг хандлагын талаар мэдээлэлтэй болсон байна.
- Сурагчид мэргэжлээ зөв сонгох талаар ойлголт, мэдээлэл нэмэгдсэн байна.
- Нарийн мэргэжлийн талаарх мэдлэг мэдээлэлтэй болсон байна
- Төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирсан байна.

219

ГБХЗХгазрын даргын 2021 оны
06 сарын 03-ны өдрийн 144
дугаар тушаалын 2-р хавсралт

“ИРЭЭДҮЙН ЭЗЭД-2021” МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН АЯНЫ ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт зардал	Хаанаас
Ном /Мэргэжил бүхэн сайхан цуврал контентод оролцсон сурагчдын дурсгалын зүйл/					ГБХЗХГ
1	Өгүүлэгчийн хүн	1	12000	12000	
2	Миний мөрөөдөл	1	17000	17000	
3	Хүн өөрийгөө бүтээдэг	1	25000	25000	
4	Хэрхэн санаа зоволгүйгээр амар тайван амьдрах	1	22000	22000	
5	Бодол биеллээ олдог	1	12000	12000	
6	НОУ-ХАУ	1	22000	22000	
7	5-секундийн дүрэм	1	22000	22000	
8	Мөрөөдөгч	1	16000	16000	
9	Коучинг дадал	1	18000	18000	
10	Зөвлөх урхи	1	22000	22000	
11	Тууз	10	1000	10000	
Нийт			**198 000**		

D:/Бичиг хэрэг /тушаал